

УЛААНБААТАР ХОТЫН ХҮЙТНИЙ УЛИРЛЫН АГААРЫН ЧАНАРЫН ЧАНАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ
/2023 оны 03 дугаар сар/


Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 18 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багажаар тодорхойлдог.

Улаанбаатар хотын 2023 оны хүйтний улирал 03 дугаар сарын агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе буюу 2022 оны 03 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад PM10 тоосонцор 3 мкг/м³-ээр буюу 3 %-иар, PM2.5 тоосонцор 1 мкг/м³-ээр буюу 3 %-иар, азотын давхар исэл (NO₂) нь 2 мкг/м³-ээр буюу 5 %-иар тус тус их, харин хүхэрлэг хий (SO₂) нь 30 мкг/м³-ээр буюу 36 %-иар бага байна.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м ³	
	Хүлцэх агууламж, мкг/м ³	2022 оны 03 дугаар сар	2023 оны 03 дугаар сар
PM10 тоосонцор	100	95	98 ↔
PM2.5 тоосонцор	50	36	37 ↔
Азотын давхар исэл, NO ₂	50	41	43 ↔
Хүхэрлэг хий, SO ₂	50	82	52 ↓

Улаанбаатар хотын сүүлийн 6 жил буюу 2018-2023 оны 03 дугаар сарын хүйтний улирлын гол бохирдуулах бодис тус бүрийн агууламжийг дараах хэсэгт дэлгэрэнгүй үзүүлээ.


PM10 тоосонцор



Зураг 1. Хүйтний улирлын PM10 тоосонцрын сарын дундаж агууламж, 2018-2023 он

Агаар дахь PM10 тоосонцрын 2023 оны 03 дугаар сарын дундаж агууламж 98 мкг/м³ байна. Өмнөх оны мөн үе буюу 2022 оны 03 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 3 %-иар их. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас даваагүй байна. (Зураг 1).


PM2.5 тоосонцор



Зураг 2. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2018-2023 он

Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцор 2023 оны 03 дугаар сарын дундаж агууламж 37 мкг/м³ байна. Өмнөх оны мөн үе буюу 2022 оны 03 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 3 %-иар их. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас даваагүй байна. (Зураг 2).


Азотын давхар исэл (NO₂)



Зураг 3. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2018-2023 он

Азотын давхар ислийн 2023 оны 03 дугаар сарын дундаж агууламж 43 мкг/м³ байна. Өмнөх оны мөн үе буюу 2022 оны 03 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 5%-иар их. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас даваагүй байна. (Зураг 3).

Хүхэрлэг хий (SO₂)



Зураг 4. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2018-2023 он

Агаар дахь хүхэрлэг хийн 2023 оны 03 дугаар сарын дундаж агууламж 52 мкг/м³ байна. Өмнөх оны мөн үе буюу 2022 оны 03 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад 36%-иар бага. Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 дахь хүлцэх агууламжаас 1 дахин их байна. (Зураг 4).

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС